

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/03

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар компьютер, техник хэрэгсэл хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Батсайхан (Татварын улсын байцаагч)

Гишүүд: Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Б.Ууганцэцэг (Нийгмийн даатгалын байцаагч)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хяналт, шалгалт олон нийттэй харилцах мэргэжилтэн)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэн хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Батсайхан)-д даалгасугай.

3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан компьютер, техник хэрэгслийг Засаг даргын Тамгын газрын өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам), Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ